



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 09 сарын 10 өдөр .

Дугаар 20

Арвайхээр

Тогтоол хүчингүй болгох, өөрчлөлт
оруулах тухай

“Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 25.4 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Захиргааны ерөнхий хуулийн дагуу үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн санд бүртгэснээр хүчин төгөлдөр мөрдөгдөх болсонтой холбогдуулан Арвайхээр хотын ногоон байгууламжийн хязгаарлалтын бүсэд тогтоох төлбөр, хураамжийн хэмжээг захиргааны хэм хэмжээний акт боловсруулах аргачлалаар төслийг боловсруулж, өөрчлөлт оруулсугай.

2. Арвайхээр хотын ногоон байгууламжийн хязгаарлалтын бүсэд тогтоох төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай шийдвэрийн төслийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг сумын Засаг дарга бөгөөд хотын Захирагч /О.Пүрэвдорж/-д даалгасугай.

3. Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Арвайхээр хотын ногоон байгууламжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 24 дүгээр тогтоолыг 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.АМАРТҮВШИН

